

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГА Ж.ГАНБОЛД

2024 оны 08 дугаар сарын 09-ний өдөр



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАРТ АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны 08 дугаар сарын 09

Аудит хийх огноо:	2024.08.09		
Аудитын дугаар:	01		
Харилцагчийн нэр:	Нийслэлийн Биеийн тамир, спортын газар		
Аудитын зорилго:	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлж байгаа ажил арга хэмжээ нь чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлэхэд шалгуур үзүүлэлтэд нийцэж байгаа эсэхийг тодорхойлох нь дотоод аудитын зорилго оршино.		
Хамрах хүрээ:	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс, Спорт, нийтийн биеийн тамирын хэлтэс		
Аудит хийх стандарт:	ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлэх		
Аудит хийсэн огноо:	Эхлэх: 2024.08.09	Дуусах: 2024.08.12	
Аудитын баг	Нэр	Үүрэг	Мэргэшсэн байдал
	Э.Мөнх-Эрдэнэ	Багийн ахлагч	Аудитор
	А.Намуун	Багийн гишүүн	Аудитор
	Б.Оюунтуяа	Багийн гишүүн	Нарийн бичиг

Нийслэлийн биеийн тамир, спортын газрын үйл ажиллагааны төлөвлөгөө

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Байршил	Оролцох албан хаагчид
1	Нээлтийн хурал	2024.08.09	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 23 дугаар хороо Арцтын ам, наадамчдын зам 1200, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын цогцолбор барилгын "Б" блок 1116 тоот	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга М.Цогзолмаа, ахлах мэргэжилтэн Г.Бямбасайхан, мэргэжилтэн Н.Өлзийжаргал, А.Намуун, Б.Оюунтуяа, У.Буян-Орших Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн дарга С.Саранцэцэг, ахлах мэргэжилтэн Э.Мөнх- Эрдэнэ
			Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг	

2	Хоолны завсарлага	2024.08.09 11:00 – 11:30	23 дугаар хороо Арцтын ам, наадамчдын зам 1200, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын цогцолбор барилгын “Б” блок 1116 тоот	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын албан хаагчид
3	Ажлын байр, оффис	2024.08.09- ний 12:00- 12:30 цагт	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 23 дугаар хороо Арцтын ам, наадамчдын зам 1200, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын цогцолбор барилгын “Б” блок 1116 тоот	Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн дарга С.Саранцэцэг, Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга М.Цогзолмаа, ахлах мэргэжилтэн Г.Бямбасайхан, мэргэжилтэн Н.Өлзийжаргал, У.Буян-Орших
4	Ярилцлага хийх албан хаагч Э.Мөнх- Эрдэнэ А.Намуун Б.Оюунтуяа	2024.08.09 12:30 – 13:30	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 23 дугаар хороо Арцтын ам, наадамчдын зам 1200, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын цогцолбор барилгын “Б” блок 1116 тоот	Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн дарга С.Саранцэцэг
5		2024.08.09 13:30 – 14:30		Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга М.Цогзолмаа
6		2024.08.09 14:30 – 15:00		Ахлах мэргэжилтэн Г.Бямбасайхан
7		2024.08.09 15:30 – 16:00		Мэргэжилтэн Н.Өлзийжаргал
8		2024.08.09 16:00 – 16:30		Мэргэжилтэн У.Буян-Орших
9	НБТСГ-ын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс, Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн баримт бичигтэй танилцах	2024.08.09 12:00-14:00	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 23 дугаар хороо Арцтын ам, наадамчдын зам 1200, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын цогцолбор барилгын “Б” блок 1116 тоот	Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн дарга С.Саранцэцэг
10		2024.08.09 14:00-17:00	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 23 дугаар хороо Арцтын ам, наадамчдын зам 1200, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын цогцолбор барилгын “Б” блок 1116 тоот	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга М.Цогзолмаа, ахлах мэргэжилтэн Г.Бямбасайхан, мэргэжилтэн Н.Өлзийжаргал,
11	Аудитын багийн хурал	2024.08.12-ны 10:00	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 23 дугаар хороо Арцтын ам, наадамчдын зам 1200, Нийслэлийн	Э.Мөнх-Эрдэнэ А.Намуун Б.Оюунтуяа

			нутгийн захиргааны байгууллагын цогцолбор барилгын "Б" блок 1116 тоот	
12	Аудитын хаалтын хурал	2024.08.12-ны 13:00	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 23 дугаар хороо Арцтын ам, наадамчдын зам 1200, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын цогцолбор барилгын "Б" блок 1116 тоот	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга М.Цогзолмаа, ахлах мэргэжилтэн Г.Бямбасайхан, мэргэжилтэн Н.Өлзийжаргал, А.Намуун, Б.Оюунтуяа, У.Буян-Орших Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн дарга С.Саранцэцэг, ахлах мэргэжилтэн Э.Мөнх- Эрдэнэ

ЗӨВШӨӨРСӨН:
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГА Ж.ГАНБОЛД

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
ЭРХ ЗҮЙ, ТОГТООД ШИЙДВЭР
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН А.НАМУУН



ДОТООД АУДИТЫН ҮЕД ХИЙСЭН АЖИГЛАЛТ

Байгууллагын нэр: Нийслэлийн Биеийн тамир, спортын газар		
	Алба, хэлтэс: Захиргаа, төлөвлөлт санхүүгийн хэлтэс	Аудитад хамрагдаж байгаа үйл ажиллагаа: хэлтсийн төлөвлөгөөний хэрэгжилт
Аудитээр шалгуулагч алба, хэлтэс: Захиргаа, төлөвлөлт санхүүгийн хэлтэс		
Д/д	Ажигласан зүйл	Тэмдэглэл
1.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын 2.2.5-д заасан бичиг хэргийн ажилтны эрх, үүргийг хэрэгжилт хангалтгүй, MNC5140-1:2021 стандартын хавсралтаар баталсан дагалдах хуудсын ашиглалт нийт албан хаагчдын хувьд хангалтгүй байна.	Албан хэрэг хөтлөлтийн стандартын хэрэгжилтэд Архив, бичиг хэргийн эрхлэгч тогтмол хяналт тавьж ажиллах.
2.	Байгууллагын https://sport.ub.gov.mn/ цахим хуудсанд оруулсан мэдээ, мэдээлэл хангалтгүй.	Нийт албан хаагчид байгууллагын сайтад байршуулах мэдээ, мэдээллийг бэлтгэж, хянуулан өгч хэвших.
3.	Нийслэлийн хэмжээнд биеийн тамир, спортын чиглэлээр судалгааг тогтмол авч баяжилт хийж байх.	Үйл ажиллагаандаа тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллах.
Дотоод аудиторовн нэр гарын үсэг: <i>А. Намуун</i> (А.Намуун)		

Байгууллагын нэр: Нийслэлийн Биеийн тамир, спортын газар		
	Алба, хэлтэс: Спорт, нийтийн биеийн тамирын хэлтэс	Аудитад хамрагдаж байгаа үйл ажиллагаа: хэлтсийн төлөвлөгөөний хэрэгжилт
Аудитээр шалгуулагч алба, хэлтэс: Спорт, нийтийн биеийн тамирын хэлтэс		
Д/д	Ажигласан зүйл	Тэмдэглэл
1.	Спорт, нийтийн биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулахад санхүүжилт бага зардал байна.	Спортын холбоодоор гүйцэтгүүлж буй ажил, арга хэмжээний төсвийг нэмэгдүүлэх.
2.	Тамирчдад олгож буй мөнгөн шагнал, урамшууллын хэмжээ бага байна.	Шагнал урамшуулал олгох журмыг Биеийн тамир, спортын Улсын хорооноос чиглэл авч боловсруулах шаардлагатай.
Дотоод аудиторовн нэр гарын үсэг: <i>Э. Мөнх-Эрдэнэ</i> (Э.Мөнх-Эрдэнэ)		

НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАРТ ЯВУУЛСАН
ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

Тайлангийн дугаар:

Шалгуур баримт бичиг:

Дотоод аудит явуулсан огноо: 2024.08.09

Дотоод аудит хийсэн ажилтны нэр, албан тушаал:

Э.Мөнх-Эрдэнэ-Спорт, нийтийн биеийн тамирын ахлах мэргэжилтэн / ахлах аудитор/

А.Намуун-Эрх зүй, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн

Б.Оюунтуяа-Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн

Дотоод аудит хийлгүүлсэн нэгжийн нэр: Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс, Спорт, нийтийн биеийн тамирын хэлтэс

ТАЙЛАН	
1. Нийт 6 шалгуураар дотоод аудитыг хийсэн.	
2. Аудитын явцад ажиглагдсан сайн талууд: Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын албан хаагчид олон жил байгууллагадаа ажилласан туршлагатай, ажлын зохион байгуулалт сайн.	
3. Аудитын явцад үл тохирол илэрээгүй.	
4. Сайжруулах шаардлагатай дараах асуудлыг гаргав. Үүнд: -Ажил хариуцсан мэргэжилтнүүдийг тогтмол мэдээллээр хангах; -Дотоод хяналт, дотоод аудитыг зааглах, албан тушаалын тодорхойлолтод тусгах; -Хэлтэс тус бүр хяналтыг сайжруулах; -Удирдлагууд, холбогдох дээд газраас ирсэн мэдээллийг мэргэжилтнүүдэд шуурхай үүрэг даалгавар өгч ажиллах.	
4 Дотоод аудиторын дүгнэлт: Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын үндсэн үйл ажиллагаанд Чанарын менежментийн ISO 9001:2015 тогтолцоог нэвтрүүлэхэд стандартын 4.1, 4.2, 5.2, 6.2, 7.2, 9.1.2 нийт 6 шалгуурын шаардлагад нийцсэн байна.	
Тайлан бичсэн:	Ахлагч <i>Э.Мөнх-Эрдэнэ</i> (Э.Мөнх-Эрдэнэ)
	Гишүүн <i>А.Намуун</i> (/А.Намуун)
	<i>Б.Оюунтуяа</i> (Б.Оюунтуяа)
Огноо: 2024.08.12	
Энэхүү тайлантай уншиж танилцсан:	
НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА <i>О.Ж.ГАНБОЛД</i>	
Алба, хэлтсийн төлөөлөгч:	
СПОРТ, НИЙТИЙН БИЕЙН ТАМИРЫН ХЭЛТСИЙН ДАРГА <i>С.САРАНЦЭЦЭГ</i> (С.САРАНЦЭЦЭГ)	

**НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ҮНДСЭН
ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ГҮЙЦЭТГЭЖ БУЙ ДОТООД
АУДИТЫН ХУРАЛ**

Газрын үндсэн чиг үүргийн хүрээнд гүйцэтгэж буй дотоод аудитын анхдугаар хурлыг 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 13 цаг 00 минутаас Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын цогцолбор барилгын “Б” блок 1116 тоот өрөөнд зохион байгуулж, хурлыг газрын дарга Ж.Ганболд удирдан явуулав.

Хуралд: Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дарга Ж.Ганболд, Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга М.Цогзолмаа, Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн дарга С.Саранцэцэг, Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Бямбасайхан, Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Мөнх-Эрдэнэ, Хэвлэл мэдээлэл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Н.Өлзийжаргал, Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн Б.Оюунтуяа, Эрх зүй, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн А.Намуун, Архив, бичиг хэргийн хэргийн эрхлэгч У.Буян-Орших 9 хүний бүрэлдэхүүнтэй ирц 100 хувьтай хуралд оролцлоо.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ – 1:

Газрын үйл ажиллагаанд дотоод аудит хийгдэх нээлтийн хурал

ХЭЛЭЦСЭН НЬ – 1:

Ж.Ганболд: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Манай газрын 3 албан хаагч “Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 дотоод аудитын сургалтад хамрагдаж, албан ёсны дотоод аудиторын гэрчилгээтэй эзэмшсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийхээр төлөвлөсөн. Тиймээс та бүхэн бүх талаар нь дэмжиж өөр өөрсдийн үндсэн чиг үүргийн хүрээнд гаргаж өгөх баримтууддаа гаргаж өгч, дотоод аудит хийлгүүлээрэй.

Б.Оюунтуяа: За баярлалаа таньд юуны өмнө манай байгууллага болон Нийслэлийн 18 агентлагт 2023 оны 03 дугаар сараас эхлэн чанарын менежментийн тогтолцоо ISO суулгах ажил эрчимтэй эхэлсэн.

Өнөөдөр хийгдэх аудитын зорилго нь Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 хэрэгжиж байгаа эсэх тохирлыг шалгах, нийт албан хаагчдын мэдлэгийг шалгах бөгөөд байгууллага болон түүний төлөв байдлыг ойлгох, сонирхогч талуудын хэрэгцээ ба найдлыг ойлгох, бодлого, чанарын зорилтууд, зорилтуудад хүрэхэд чиглэсэн төлөвлөлт, чадамж, хэрэглэгчийн сэтгэл ханамж гэсэн стандартад тусгагдсан шалгуураар хамрах хүрээгээ тодорхойлсон бөгөөд аудитын үйл ажиллагааг 15:00 цагт дуусгана.

Мөн дээрээс нь нэмж хэлэхэд 6 шаардлагад манай байгууллагын үйл ажиллагаа хэрхэн нийцэж байгааг шалгана гэсэн үг. Та бүхэнд тус төлөвлөгөөтэй холбоотой асуулт байна уу?

Г.Бямбасайхан: Аудитаа яаж үнэлдэг юм бол хийж буй ажлаа ямар шалгуур үзүүлэлтээр үнэлж үзээд болсон болоогүй гэдгийг нь мэдэх боломжтой вэ?

Б.Оюунтуяа: Аудит үнэлэхгүй. Аудитыг хийхдээ дандаа нотлох баримтад тулгуурлан асуулт асуугаад тийм, үгүй асуултын хүрээнд нотлох баримтаа хараад хийнэ гэсэн үг. Жишээ нь танай байгууллага стратеги төлөвлөгөөгөө хийдэг үү? 2024 онд хийсэн үү гэж асуухаар тэр төлөвлөгөө, тайлангаа баримтуудаа харуулаад түүн дээр тулгуурлаад лавлаж тодруулж ажиллах юм.

Тэгээд энэ баримт байгаа учир энэ стандартад нийцэж байна гэж үзнэ. Амаараа манайд байгаа тийм ажил хийдэг гэж мянга хэлээд ч түүнийг баримтаар баталгаажуулахгүй бол тус ажлыг аудитын шаардлагад нийцэхгүй байна баталгаажуулах боломжгүй гэж үзнэ.

Аудитын явцад үл тохирол илэрвэл ажлын даалгавар өгч засан сайжруулах арга хэмжээ авхуулна. Мөн та бүхэн маань нэг зүйлийг маш сайн ойлгоорой энэ удаагийнх анхны аудит хийгдэж байгаа цаашид энэ 3 маань сайжраад, суралцаад л явна гэсэн үг. Тиймээс 3 аудитораа дэмжээд өгөөрэй. Ер нь аудит гэдэг нь ярилцлагын үндсэн дээр баримтжуулж хийгддэг ажил юм.

М.Цогзолмаа: Манай хийсэн аудитад гадны аудит орох уу?

Б.Оюунтуяа: ISO 9.2 дээр байгууллага чанарын менежментийн тогтолцоо буюу чанарын шаардлага хэр их бууж байна вэ гэдгийг тохирлын нийцлийг нь тодорхойлох гэж аудит хийж байгаа. Тус аудитыг дотоод аудиторын сургалтад хамрагдаж сертификат авсан хүн хийх ёстой учраас манай 3 мэргэжилтэн хамрагдсан юм. Дотоод аудитыг хийх зорилгууд олон ч зайлшгүй 2 зорилго байгаа. Нэгдүгээрт нийцлийн тохирлыг үнэлэх буюу хүмүүстээ цочрол өгнө, нөгөө талаараа хөндлөнгийн аудитад бэлдэх зорилгоор хийгдэнэ. Өөр тодруулах зүйл байгаа юу? За байхгүй бол дотоод аудитаа эхлүүлье.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ -1:

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэлийг тайлагнах.

ХЭЛЭЛЦСЭН -2:

Газрын үйл ажиллагаанд дотоод аудит хийгдэх нээлтийн хурал

ХЭЛЭЦСЭН НЬ – 2:

Б.Оюунтуяа: Байгууллагын үйл ажиллагаанд 6 шалгуур үзүүлэлтийн дагуу дотоод аудит хийсэн. Аудитын явцад үл тохирол илрээгүй бөгөөд сайшаалтай тал их байна гэж харлаа. Учир нь албан хаагчид олон жил ажилласан туршлагатай, ажлын зохион байгуулалт сайн, өөрсдийнхөө хийж буй ажлын үр дүн, явц, төлөвлөгөөг маш сайн мэдэж байна. Аудитын явцад сайжруулах шаардлагатай дараах 4 ажил байна. Үүнд:

- Ажил хариуцсан мэргэжилтнүүд удирдлагыг тогтмол мэдээллээр хангах;
- Дотоод хяналт, дотоод аудитыг зааглаж албан тушаалынхаа тодорхойлолтод тусгах;
- Хэлтэс тус бүр дотооддоо хяналтыг сайжруулах;
- Удирдлагууд, холбогдох дээд газраас ирсэн мэдээллийг мэргэжилтнүүдэд шуурхай үүрэг даалгавар өгч ажиллах шаардлагатай байна.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын үндсэн үйл ажиллагаанд Чанарын менежментийн ISO 9001:2015 тогтолцоог нэвтрүүлэхэд стандартын 4.1, 4.2, 5.2, 6.2, 7.2, 9.1.2 гээд нийт 6 шалгуурын шаардлагад нийцсэн байна.

Ж.Ганболд: За манай гурван мэргэжилтний хийсэн аудитын дүгнэлттэй холбоотой санал байна уу? Бид цөөхүүлэхнээ хийх ажил нь их учраас зарим зүйлийг баталгаажуулж авч үлдэх тал дээр хойрго хандсан байж болох ч ерөнхий рамаараа манай газар сайн ажилладаг гэж хувьдаа үздэг.

Өөр асуулт, саналтай хүн байна уу? Байхгүй бол өнөөдрийн хурлыг өндөрлөж аудитын тайланг танилцаж зөвшөөрсөн тул гарын үсгээ зурж баталгаажууллаа. Та гуравтаа амжилт хүсье. Сайн суралцаарай.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ-2:

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайланг баталгаажуулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст албан бичгээр хүргүүлж, ажиллахыг Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн Б.Оюунтуяад үүрэг болгов.

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГА **Ж.ГАНБОЛД**

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН
ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН **Б.ОЮУНТУЯА**

